

Бага насны хүүхдийн сөрөг зан үйлийг судалсан судалгааны үр дүн

С.Тулга*

Хураангуй

Гэр бүл бол хүүхдийн анхдагч амьдрах болон хүмүүжлийн орчин. Хүүхдийн амьдралын эхэн үед гэр бүл хүүхдийн хүмүүжилд чухал нөлөөтэй. Бие хүний төлөвшилд ямар гэр бүлд өссөн тийм хүн болдог тул гэр бүлийн үүрэг их хамааралтай. Эцэг эхийн хүмүүжил нь гэр бүлийн амьдрал хүүхдийн хүмүүжлийг бий болгодог. Гэр бүлийн амьдрал нь маш хүчтэй, байнга, тогтмол, үл мэдэгдэх байдлаар бидний бие махбодыг бэхжүүлж эсвэл хордуулж байдаг агаар шиг хүний үзэл бодлыг хүчирхэгжүүлж эсвэл хордуулдаг. Гэр бүлийн хүмүүжлийг амжилттай болгохын тулд эцэг эх нь зөвхөн зөвлөх төдийгүй, өөрийн хүүхдийн онцлогийг тохирсон олон арга хэрэглэх явдал. Хүүхдийн хөгжлийн бүх үе шатанд эцэг эхийн үлгэр дууриалал нь чухал байдаг. Гэр бүлийн хүүхэд хүмүүжүүлэх арга гэдэг нь хүүхдийн зан төлөв ба ухамсарт нөлөөлөхөд эцэг эхийн зорилготой сурган хүмүүжүүлэх арга барил тусалдаг. Гэр бүлийн хүмүүжүүлэх арга барил, эцэг эхийн бие хүний шинж чанар хоорондоо салшгүй холбоотой. Гэр бүлд хүүхэд эхний үед амьдралын туршлагыг хүлээн авдаг, эхний ажиглалтыг хийж, янз бүрийн нөхцөлд хэрхэн ажиллахыг суралцаж байдаг. Хүүхдийн сөрөг зан үйл нь насанд хүрсэн хүнтэй харилцах хэлбэр бөгөөд энэ нь тэдний анхаарлыг татах, хүсэл мөрөөдлөө илэрхийлэх арга юм. Тиймээс хэрэв хүүхэд сөрөг зан үйл харуулсан бол тэр юуны түрүүнд иймэрхүү байдлаар юу «мэдээлэх-ийг хүсэж байна гэдгийг ойлгохыг хичээх. Янз бүрийн нөхцөлд муу зан нь: «Би юу хийхээ мэдэхгүй байна», «надад анхаарал хэрэгтэй», «Би ядардаг», «Би өөр зүйл хийхийг хүсч байна», «Би юу болж байгааг ойлгохгүй байна» гэх мэт.

Түлхүүр үг

Гэр бүл, хүүхэд, эцэг эхийн харилцаа, хүүхдийн хүмүүжил, сөрөг зан үйл

Удиртгал

Хүүхдийн хөгжил нь олон талт хүчин зүйлүүдээс хамаардаг нарийн үйл явц юм. Энэ нь эхийн хэвлийд үр тогтохоос эхлээд хорвоод мэндэлснээс хойш тасралтгүй үргэлжлэх бөгөөд хүүхэд бүрийн хөгжлийн онцлог давтагдашгүй.

Доктор, профессор, хүн судлаач Ц.Балхаажав “Хүн болох, хүн байхын ухаан” лекцэдээ хүн байна гэдэг гол юм нь ноён нуруутай, урагш тэмүүлэлтэй, зорьсноо биелүүлж бэрхшээлийг даван гарах чадвартай байх ёстой... Хүн хүндээ түшиг болохгүйгээр хүн төрөлхтөн оршин тогтнох, хөгжиж дэвшихийн арга үгүй. Тийм учраас хүнд хүнээс илүү сайн орчин гэж байхгүй хэмээн өгүүлсэн. (Балхаажав, 2010, х.188)

Судлаач Л.Дашням, Монгол хүүхдийн насны үечлэлийг тогтоож, хүмүүншүүлэх соёлын онцлог нь Монголчууд эрт дээр үеэс эхлэн хүн төрөлхтний соёлын өв дээжээс хүртэж ирсэн, түүнийг өөрийн ахуйд нийцүүлэн “монголчилж” өөрийн болгон хэрэглэж сурсан, интернационалист сэтгэхүйтэй, “харилцагч бус ханьсагч” улс болохоор оюуны соёл нь хүмүүний нийт соёлыг нэг хэсэг болон хөгжиж чадсанд оршдог гэжээ (Дашням, х.41).

Хүүхэд багачуудыг хүмүүжүүлэхэд багаас нь эцэг эхийн оролцоо нөлөөтэй. Хүүхдийн өсөлт хөгжил, хүмүүжил, төлөвшлийн асуудалд хамгийн том үлгэрлэгч, нөлөөлөгч нь эцэг эх байдаг. Гэр бүл хүн төрөлхтний боловсруулсан оюуны баялаг, амьдралын туршлагыг хамгийн энгийнээр дамжуулж өгдөг.

Хүүхдийн зан үйлийн хувийн өвөрмөц онцлог нь орчны нөлөөлөл, нийгмийн амьдралын туршлага, харилцаа, гэр бүл, сургууль зэрэг нийгмийн бичил бүлгүүдийн харилцан үйлчлэл, өөртөө хандах хандлага болон аливааг үнэлэх нийгмийн үнэлэмж, баримжаалалд гарч буй өөрчлөлтийг багтаадаг. (Бүрэнжаргал, Ариунсанаа, 2005, х.177) Гэр бүлийн нөхцөлд хүүхдэд үзүүлж байгаа зан үйлийн үлгэр дуурайлал нь хүүхдэд өөрийн гэсэн нийгмийн туршлага хуримтлуулахад нөлөөлж байдаг ба хүүхдийн ертөнцийг үзэх үзлийн анхны ойлголт бүрэлдэн тогтдог. В.А.Сухомлинский (1918-1970), Гэр бүлийн амьдралын утга учир, зорилго бол хүүхдээ хүмүүжүүлэх явдал мөн. Хүүхдийг хүмүүжүүлэх гол сургууль бол эцэг эхийн харилцаа юм. (Хатанбаатар, 1978, х.57) Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн 80-90 хувь нь эцэг эх, гэр бүлийн нөлөөнөөс бий болдог гэж

* ✉ Sanjaadorj_tulga@yahoo.com

Европын судлаачид үзсэн байдаг.

Эрдэмтдийн үзэж байгаагаар хүн байгальтай уялдаж бие, сэтгэлийн ухааны иж бүрэн нэгдэлд зайлшгүй үе шаттай, тогтолцоогоор хүмүүждэг болохыг харуулж байна. Тухайлбал хүүхдийг төрөнгүүт биеийн хүмүүжилд нь анхаараад, түүг дээрээ тулгуурлаж сэтгэлийн болоод ухааны хүмүүжилд нь анхаарахыг онцолж байжээ. Монголчууд нийтээр хүүхдийн бойжих, өсөн торних үйл явцыг олон жилийн турш ажиглаж тодорхой туршлага, мэдлэг хуримтлуулан түүндээ түшиглэн хүүхдийн нас бие, сэтгэцийн онцлогийг үечлэн тогтоожээ. Ингэхдээ янз бүрийн үндэслэлийг баримталдаг байжээ. Тухайлбал: 0-5 нас нь хан хөвгүүн мэт асар, 6-10 насанд нь биедээ сүүдэр мэт дагуул, 11-15 насанд бие даалга, 16 наснаас нь найз нөхөд мэт харилц хэмээсэн нь хүүхдийн насыг хүүхдийн хөгжилд гарах чанарын өөрчлөлт дээр үндэслэн үечилж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр гаргажээ (Намжил, 2005, х.195-196).

Тиймээс хүүхдийн зан үйл нь 3-6 нас, 11-15 нас, 15-18 насны хооронд хүүхдийн зан үйлд зарим өөрчлөлт гардаг. Хүүхдийн зан үйлд эергээр нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол насанд хүрэгчдийн хувийн үлгэр дуурайлал байдаг байна. Гэр бүлийн доторх аж байдал, соёл, ёс суртахуун, эцэг эхийн зөв харилцаа зэрэг нь хүүхдэд үлгэр загвар болдог. Иймд эцэг эхчүүд хүүхдийнхээ зан үйлийг байнга ажиглаж засаж залруулах тэдний ааш занг нь эвдрэхээс болгоомжлон ярилцаж байх нь зүйтэй гэж судлаачид үздэг. Хүүхэд бүр эцэг эхтэйгээ, тэднийхээ хайр халамжид хүмүүжин иргэний төлөвшилтэй болох, нийгэм, гэр бүлийн дэмжлэгт орчныг бүрдүүлэх хэрэгтэйг өнөөдрийн нийгмийн хурдтай хөгжил, техник технологийн эрин зуунд чухлаар тавигдаж байна. Иймээс “Гэр бүл- хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин” эцэг эхийн үндэсний зөвлөгөөн 2017 оны 9 сарын 15-нд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын ивээл дор зохион байгуулагдсан. Гэр бүл бүхэн өөрийн үнэт зүйлсээ дээдлэн хөгжүүлж, үр хойчдоо уламжлан үлдээж байх нийгмийн үүрэгтэй гэжээ.

Орчин цагт амьдралын хэв шинжүүд өөрчлөгдөн гэр бүлийн янз бүрийн хэв маяг шинээр үүсэж байгаа нөхцөлд цөөн хүн амтай манай орны хувьд гэр бүлийн боловсролыг шинжлэх ухааны үндэслэлтэй, гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлэн олгох нь улс орны төдийгүй хүний хөгжлийн чухал асуудал юм” гэж үзсэн. (Эрдэнэбат, 2017, х.4) Хүний хөгжлийн асуудлыг эхийн хэвлийд үр хөврөл тогтож эхлэх үеэс анхаарах нь хүүхдийн эсэн мэнд бойжих, хөгжихөд төдийгүй насан

туршийн амьдралд нь нөлөөлдөг болохыг эрдэмтэд нэгэнт баталсан. Хүний хөгжлийн суурь, эрчимтэй хөгжлийн үе бол 0-6 нас бөгөөд энэ насны бүлгийг “бага насны хүүхэд” хэмээн нэрлэдэг. Хүүхэд байхдаа туулсан амьдралын туршлага нь хүний насан туршийн амжилт бүтээлд нөлөөлдөг учраас бага нас бол хүний өсөлт, хөгжлийн маш чухал үе юм.

Бага насны хүүхэд бол төрөлхийн сониуч зангаараа хүрээлэн буй орчноотань жмэдэх их хүсэл эрмэлзэлтэй, аливааг оролдож хийхийг чармайдаг, харилцааны явцад зөв буруу, сайхан муухайг ялган салгаж, бусдын дунд дасан зохицох чадвартай, идэвхтэй суралцагч юм. Хүүхдийн хувийн зан төрх бүрэлдэн, ирээдүйд ямар хүн болоход нэг талаас гэр бүлийн гишүүдийн харилцаа, хандлага, хүүхдээ хүмүүжүүлж байгаа арга барил буюу гэр бүлийн боловсрол хамгийн чухал. Хүүхэд бол эцэг эхийн толь юм. Бага насны хүүхдийн хувьд авч үзвэл тэд эцэг эхийн хайр халамжийг татах гэж тэднээр илүү их хайрлуулахыг хүсэн янз бүрийн зан үйл гаргаж байдаг. (“<http://teacher.itpd.mn>- зан төлөвийн өөрчлөлтийн талаар”)

-эцэг эхээсээ материаллаг болон материаллаг бус зүйлийг хүсэх, ганцаардсан үедээ хуруугаа хөхөх, хумсаа мэрэх, хамраа ухах, удаан хугацаагаар гөлрөх, гар хуруугаар байнга оролдох ямар нэгэн хөдөлгөөнөөр түүнийгээ илэрхийлэх гэх мэт.

- Нийгэм сэтгэл зүйн сөрөг хүчин зүйлс: Эцэг эхийн буруу нөлөө, буруу хүмүүжил, муу зуршилд автамтгай хүүхэд, хараа хяналтгүй өсөж хүмүүжиж буй хүүхэд, хүүхдийг “гэрийн бурхан болгон шүтэх”, шоовдорлох, хатуу гарын, асрамж халамж дутсан хүмүүжил, салсан гэр бүл, хуурамч эв түнжинтэй гэр бүл гэх мэт.

- Зан төлөвийн өөрчлөлтийн гол онцлог шинжүүд: огцом түргэн зантай, уур уцаар ихтэй, зөрүүд зантай, бусадтай харилцах эв дүйгүй, хэрцгий догшин ааш авиртай, хорт муу зуршилд дассан, автамтгай, биеэ тоосон, өөрийнхөө дураар, тэвчээргүй, сахилгагүй, хоржин зантай, нийц таарамж муутай, нэр нүүргүй аашилдаг, шуналтай, зарим тохиолдолд идэвх санаачилга ихтэй мэт болдог, зөрүүд зоргоороо авирлах, сэтгэлээр амархан унах зэрэг шинжүүд дахин дахиагдаж байдаг онцлогтой. Ялангуяа ичимхий, шантрамтгай, харимхай, хулчгар зан ааш зонхилон илэрч байдаг байна.

Бага насны хүүхдийн нийтлэг онцлог бол бусдыг дуурайх явдал юм. Эерэг зөв үйлдлийг дуурайх нь сайн бол, буруу сөрөг үйлдлийг дуурайх нь цаашид буруу дадал хэвшилтэй болох сөрөг үр

дагавартай. Иймд балчир насны хүүхдийн дэргэд томчууд муухай үг хэлэх, гаж буруу үйлдэл хийхээс зайлсхийвэл зохино. Гэр бүл нь амгалан тайван амьдарч, гадны хүмүүстэй нөхөрсөг харьцаж болно, эсвэл эсрэгээрээ маргаантай, харгис хэрцгий байдал нь хорт хавдар, өвчин үүсгэдэг учир гадны хүмүүст төдийгүй, хайртай хүмүүстээ ч хамаатай. Гэр бүлийн оюунлаг сонирхол, уран бүтээл туурвих, эсвэл зөрчил мөргөлдөөн, эдийн засгийн тогтворгүй байдалтай амьдарч болно. Гэр бүлийн амьдрал хүчтэй, түүний сэтгэгдэл тогтмол, энгийн, гэхдээ үл мэдэгдэх, бидний бие махбодыг амьсгалж буй агаар шиг хүний үзэл бодлыг хүчирхэгжүүлдэг эсвэл хордуулдаг байна. (Лесгафт, 2010, х.218).

Орчин үеийн судлаачид судалгааны дүгнэлтэд зургаан настны зан үйлийн сөрөг байдал, бусдыг үл хүндэтгэсэн ааш авир тухайн хүүхэд насанд хүрсэн хойноо хүчирхийллийн болон хүчирхийлэл бус шинжтэй гэмт хэрэг үйлдэх магадлалтайг судалгаагаар тогтоожээ. Канадын Монреалийн их сургуулийн шинжээчид зургаан настайдаа зодоон хийдэг, үгэнд ордоггүй, бусдад санаа зовдоггүй, өрөвч биш хүүхэд 24 насандаа гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөр болохыг нотолжээ. Мөн доктор Шейла Ходжинс “Medscape” эрүүл мэндийн сэтгүүлд өгсөн ярилцлагадаа “Хүчирхийллийн болон хүчирхийллийн бус шинжтэй ихэнх гэмт хэргийг хүүхэд насанд нь зан үйлийн согог тогтож, насан туршид нь үргэлжилсэн цөөн хүмүүс үйлддэг. Зан үйлийн согогийг эрт оношилж, эмнэвэл хүүхэд өөрчлөгдөж эрүүл, аз жаргалтай амьдарч, нийгэмд сөрөг бус эерэг нөлөөлөл үзүүлж чадна” хэмээжээ.

Өнөө үед эцэг эх хүүхдийн амьд харилцаагаар хүүхдийг өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээж чаддаг, бие даасан бүтээлч соёлжсон иргэд болгон хүмүүжүүлэх явдал өнөөдөр тулгамдаад байна. Хүүхэд, өсвөр үеийн хүмүүжил, төлөвшил, нийгэмшилд шинэ байр суурь, сэтгэлгээ, хандлагаар хандаж, хүүхэдтэй ажиллах арга барилаа боловсронгуй болгох зорилт эцэг эх, олон түмний тулгамдсан асуудал болж байна. Эцэг эхчүүд хүүхдийнхээ гаргаж буй зан авирыг ажиглан, юунаас болоод байгаа шалтгааныг багш, сурган хүмүүжүүлэгч нартай хамтран судлан, ажиглан, хүмүүжлийн олон янзын арга барил хэрэглэх шаардлагатай байна.

Зорилго: бага насны хүүхдэд илрэх сөрөг зан үйлийг ажиглалтын аргаар судлан, дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны арга: баримт бичиг, ажиглалтын арга,

Судалгааны объект: ХУД-ын 49, СХД-ийн 90 дүгээр цэцэрлэгийн 34 хүүхэд

Судалгааны арга зүй


Р.Г.Гуровийн бүтээлүүд хүмүүжлийн арга барил, арга зүй, судалгааны аргуудын талаарх нийгмийн асуудалд гол анхаарлаа хандуулдаг. (Гурова, 1981, х.45, 46) Хүмүүжлийн асуудлын ажиглалттай холбоотой дараах элементүүдийг анхаарч үзэх хэрэгтэй хэмээн үзсэн. Үүнд:

1. оролцогч - насанд хүрэгчид ба хүүхдүүд (тэдний товч тодорхойлолт);
2. тэдгээрийн хоорондох харилцан үйлчлэлийн хэлбэр, насанд хүрэгсдийн нөлөөллийн хэрэгсэл,
3. насанд хүрэгчид болон хүүхдүүдийн хоорондох харилцаа, хүүхдүүд хоорондох харилцаа, үр дүнтэй харилцааны үр нөлөө зарим үзэгдлийн давтагдах чадвар
5. хэвийн зан үйлээс хазайх;
6. үг, үйлдлүүдийн зөрчилдөөн;
7. насанд хүрэгчид болон хүүхдүүдийн хувь хүний онцлог шинж.

Ажиглалтын судалгаанд оролцогчдын товч мэдээлэл:

Насны хувьд: 3 настай 3 буюу 8.8%, 4 настай 12 буюу 35.3%, 5-6 настай 19 буюу 55.8%, хүйсийн хувьд эрэгтэй 20 буюу 58.8 хувь, эмэгтэй 14 буюу 41.2 хувь хамрагдсан байна.

Ам бүлийн байдал



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийн боловсрол, ажил хөдөлмөр эрхэлдэг:

		Эцэг		Эх	
		тоо	хувь	тоо	Хувь
Боловсрол	Дээд	15	50	21	61.7
	Тусгай дунд	4	13.3	7	20.6
	Бүрэн дунд	10	33.3	6	17.6
	Бүрэн бус дунд	1	3.3	-	-
Ажил хийдэг эсэх	Тийм	20	66.6	18	52.9
	үгүй	10	33.3	16	47.1

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэгтэйгээ хамт амьдардаггүй 4, гадаадад хөдөлмөр эрхэлдэг-2, цагдаагийн байгууллагад


ажилладаг эцэгтэй -5 хүүхэд байна. Судалгаанаас хүүхдийн зан үйлд эцэг, эхийн гэр бүлийн тогтворгүй байдал, ажил мэргэжлийн онцлог байдал, хүүхдээ хайхрах байдал, өрхийн орлогын байдал нөлөөлж байна. Тухайлбал: цагдаагийн байгууллагад эцэг нь ажилладаг хүүхдүүдэд захиран тушаах хэв шинжийн харилцаа, эцэг эхийн үл хайхардаг хүүхдүүд зожиг, үг дуу цөөн, ганцаардмал, хүүхдүүдээ тоглохгүй байх нь ажиглагдсан.

Хаана амьдардаг: гэр 7 буюу 20.6%, байшинд 6 буюу 17.6%, орон сууц 20 буюу 58.8%, хөлсний байр 1 буюу 2.9%

Эцэг эхийн анхаарал халамж: маш сайн 16 буюу 47.1%, сайн 12 буюу 35.3%, дунд, тааруу 3 буюу 17.2%, муу гэсэн 0% байна.

Судалгааны үр дүн

Хүүхэд хүмүүжүүлэх хамгийн эхний зорилго бол хүүхдэд илэрч буй сөрөг зан авирт чиглэх хэрэгтэй гэж сэтгэл судлаачид үздэг. Хүмүүжлийн процессын тухай ул суурьтай ярьж гэвэл харилцаа хэмээх зүйлийг дурдахгүй өнгөрч болохгүй гэж үздэг. Учир нь хүмүүжлийн процесс нь эцэг эх үр хүүхдийн харилцаагаар дамжиж хэрэгждэг. Эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэх ажлын хэрэгцээ нь, үр удмаа тасралтгүй үлдээх, хүмүүстэй харилцах, амьдралаа утга учиртай болгох, амжилтад хүрэх, хүүхдэдээ өөрийн хүссэн тодорхой шинж чанарыг төлөвшүүлэх, тодорхой систем, үзэл санааг хэрэгжүүлэх зэрэг болно гэжээ. (Ичинхорлоо, 2012) Ажиглалтын судалгаанд хамрагдсан хүүхдэд зөрүүд зан, өөрийнхөө дураараа байх, үгэнд орохгүй, бусадтай харилцах чадвар сул /зожиг зай барьдаг, зоддог, түлхдэг/ зэрэг шинж хэр дахин дахин давтагдаж байгааг ажигласан. Ажиглалтад хамрагдсан хүүхдүүдэд дараах сөрөг зан үйлүүд илэрч байсан.



Үйлдэл: өшиглөх, үймүүлэх, хазах, тоглоом булаах, уйлах, зоддог, цохидог, хэмсэг зангидах, юм авч шиддэг, муухай харах, бусдыг түлхэх, хүүхдийн өөдөөс дунд хуруугаа гаргадаг. Эндээс хүүхдийн сөрөг зан үйл үүсэхэд хүүхдэд нөлөөлөх орчноос, тэдэнтэй харилцаж ахмад хүмүүсийн

харилцаа хандлагаас шалтгаалж байна. Иймд эцэг эхчүүд:

- Хүүхдийн гаргаж буй сөрөг зан авир юунаас болоод байгаа шалтгааныг ажиглан судалж хүмүүжлийн эерэг арга барилд суралцан, хэрэглэх.
- Хүүхдийн өсөн торних ахуй сайжирсан, гэр бүлд хүүхдийн тоо цөөн байгаагаас үзэхэд “ганц юм, ганц үлдсэн нь, том хүү охин, бие нь сул юм, отгон нь” гэх зэрэг шалтаг шалтгаан гарган хүссэн бүхнийг өгч, өөрт нь тавих шаардлагыг сулруулах, ялимгүй зүйлээр магтан сайшаах зэрэг ухаалаг бусаар хайрлан халамжилж байна. Энэ нь бага насны хүүхдэд зөрүүд зан үүсэх гол шалтгаан нь болдгийг эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.
- Ажиглалтын явцад эцэг эхчүүд хүүхэдтэйгээ захиран тушаах, эсвэл хүүхдээ дур зоргоор байлгадаг харилцааны арга барилтай байна. Хүүхэд уур уцаартай, тогтворгүй ааш араншинтай нэгэн болоход үр хүүхэдтэйгээ эелдэг зөөлөн, найрсгаар харилцахгүйгээс болдог. Хүүхдийн бусад дээрэнгүй, түрэмгий ханддаг, зарим үед догшин хэрцгий зан үйл нь эцэг эхчүүдэд чанга хараа хяналт тавьдаг, захиргааддаг, хүүхдийн хүсэж буй хайр энхрийллийг хэзээ ч үзүүлдэггүйгээс бий болдог гэдгийг судлаачид нэгэнт баталсан. Иймээс хүүхэдтэйгээ харилцахдаа хүмүүжлийн уян хатан арга барилуудыг хэрэглэх хэрэгтэй байна. Тухайлбал, хүүхэдтэйгээ элэгсэг дотно сэтгэлээсээ харилцах ойлгуулах, хэдийгээр хүүхэд буруу хэрэг хийсэн ч гэсэн ээж нь, аав нь түүнийг үргэлж хайрладаг гэдгээ бодитойгоор харуулдаг, тайтгаруулан хамгаалдаг, хэлж ярихыг нь сонсож, бодол санааг нь хуваалцдаг, хүүхдийнхээ байр сууринаас асуудлыг харж үздэг, хүүхдэдээ ямар нэгэн асуудал бэрхшээл тохиолдвол тусалж дэмждэг, урам зориг хайрладаг, хүүхдийг зодож шийтгэдэггүй, харин зааж зөвлөн, дэмжин тусалдаг байх. Хүмүүжлийн эерэг аргыг амьдралдаа хэрэгжүүлж чадвал та хүүхдийнхээ хүмүүжилд сөргөөр нөлөөлөх бүх хүчин зүйлсийг төвөггүйгээр даван туулж чадна.

Үг хэл яриа: захиран тушаах, эсвэл үг дуу цөөн /чи муу, цааш яв, чи боль, муудлаа, чадахгүй, хүүр минь, ална шүү, ярьж чадахгүй, үгүй ээ, ёс бус үг хэллэг, хүүхэд их шоолдог.

Монгол айл гэрт бага насны хүүхдийг хүмүүжүүлэхтэй холбоотой хорио цээрээс хэл яриатай холбоотойг авч үзвэл: хүний яриан дундуур ордоггүй байх, хов хэлж болдоггүй, хараал хэлдэггүй, ахмад хүнээс урьтаж ярихыг цээрлэнэ, амар мэнд асууж байхад хариу эс дуугарахыг цээрлэнэ, аав ээж, ахмад эгчмэд болон үл таних хүнийг чи хэмээхийг цээрлэнэ гэх мэт. Бага насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх ажил нь насанд хүрэгчдийн удирдлага дор явагдах нь илүү үр дүнтэй байдаг. Хүүхдийн хэл яриа орчны хүмүүсийн хэлж ярьж байгааг дуурайх замаар хөгждөг. Тийм учраас ахмад хүмүүс өөрийнхөө хэл яриандаа байнга хяналт тавьж байх хэрэгтэй. Тухайлбал,

- Зандарч, чанга ярихгүй байх
- Хүүхэдтэйгээ эелдэг зөөлөн харилцах
- Хараалын, бүдүүлэг үг хэллэг, сул үг хэлэхгүй байх
- Хоорондоо зөв боловсон харьцах зөв ярьж сурах зэрэг. Цэцэрлэгийн багш, эцэг эхийн хэл яриа хүүхдийг хөгжүүлэх ажлын чухал хэрэглүүр болдог учраас хүүхэдтэй ажиллах үедээ үг хэллэгтэй онцгой анхаарах хэрэгтэй. Хэрэв насанд хүрэгчдийн яриа нь зөв соёлтой, хүүхэдтэй тогтмол харьцдаг, тэдний идэвхтэй яриаг дэмждэг, урамшуулан сайшаадаг бол хүрээлэн байгаа ярианы орчин хүүхдэд эерэг нөлөө үзүүлнэ. Харин хүүхдийн ярианд анхаарлаа хандуулдаггүй тэдэнтэй байнга харилцдаггүй, төвөгшөөдөг, ярианы бүтэц зохион байгуулалт нь буруу бүдүүлэг үг хэллэгтэй бол хүүхдийн хэл яриа болон сэтгэхүйн ерөнхий хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хүүхдийн сөрөг зан үйлд нөлөөлж буй нөлөөлөл: гэр бүл, эцэг эхийн харилцаа-82,3% гар утас, интернет, телевизор-29.0%, найз нөхөд, дүүтэй болсон, эцэг эхийн салалт, хараа хяналт муу, орчин, хэл ярианы бэрхшээл, айлын ганц хүүхэд, аав нь зоддог, хүүхдийн хувийн онцлог, насны онцлог, өвөө эмээгийн харилцаа зэрэг хүчин зүйлүүд ажиглагдсан.

Эдгээрийг дүгнэвэл: Бага насны хүүхдийн үйлдэл, эрүүл мэнд, амьдрал, сэтгэл, бие махбодын хөгжлийн онцлог, хүрээлэн буй орчны нөхцөл байдал болон тэдгээрийн үр дагавраас шалтгаалдаг. Эцэг эхчүүд хүүхдийн сэтгэл зүйн, биеийн болон оюун ухааны хөгжилд нөлөөлөх таатай орчинг бүрдүүлж өгөх үүрэгтэй байдаг (Жуков, 2009, х.420). Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн зан үйлд сөргөөр нөлөөлдөг гадаад

хүчин зүйлд гэр бүлийн харилцаа, орчин хамгийн их хамааралтай байна. Нөлөөлж буй хүчин зүйл: эцэг, эх нь хэрүүл, маргаан үүсгэх, гэр бүлийн гишүүний хэт өмөөрөх, хэт эрхлүүлэх, дураар нь аашлуулах, хүүхдэдээ нэр хоч өгөх, магтахгүй сайшаахгүй байх, анхаарал халамж бага тавих, загнаж аашлах, зодох зэрэг. Түүнээс гадна гэр бүлийн хүмүүжлийн уламжлалт арга барил багасаж, телевиз, интернетийн хүмүүжлээр солигдож байгаад анхаарах. 1.5-2 насны хүүхдүүд хүүхэдтэй кино үзэж, 3 настайгаас компьютер тоглоом тоглож байна. Хүн төрөлхтний хүмүүжил тэд хамтарсан үйл ажиллагааны үнэт зүйлийг хөгжүүлэхийг шаарддаггүй, виртуал ертөнцөд амьдарч байна. Хүүхдийг эерэг зан үйлтэй болоход эхний цэг нь хайр, халамж юм. Хүүхэд эцэг, эхийн хайр, халамжаар зүрх сэтгэлээ дүүргэдэг. Хэрэв үүнийг нь дүүргэж өгөхгүй бол компьютер, гар утас, найз нөхөд гэх мэт өөр зүйлсээр дүүргэдэг. Түүнчлэн хүүхдийг зодох, дарамт үзүүлэх ч үүнд нөлөөлдөг. Иймд эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгээ сайтар ухамсарлан ойлгох хэрэгтэй байна.

Дүгнэлт

Бага насны хүүхдийн сөрөг зан үйлийн ажиглалтын судалгаанаас үзэхэд:

Бага насны хүүхдийн сөрөг зан үйлд гэр бүлийн орчин, эцэг эхийн харилцаа чухал нөлөөтэй. Гэр бүл нь эхнэр нөхөр, эцэг эх, хүүхдүүдийн хоорондын харилцаа, энэ харилцаан дээр суурилсан жижиг бүлэг, гишүүд нь амьдралын нийтлэг байдал, харилцан ёс суртахууны хариуцлага, харилцан туслалцах, уялдааг зохицуулдаг нийгмийн механизм гэж тодорхойлдоггүйг анхаарах (Рыбцова, Меренков, нар, 2013, х.68-73).

Эцэг эхчүүд хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, биеийн өсөлт бойжилт, зан чанар, сэтгэлзүйд гардаг эерэг ба сөрөг өөрчлөлт, хэрэгцээ, сонирхол, үзэл хандлага зэргийг нарийн ялган мэдэж, түүндээ түшиглэн хүмүүжүүлэх уян хатан, эерэг хүмүүжүүлэх арга барилд суралцах хэрэгтэй. Учир нь,

- хүүхдийн зөрүүд зан 3 настайгаас эхэлдэг. Энэ үедээ түүний зөрүүд зангийн хэлбэр нь том хүмүүсийн дарангуйллын эсрэг хандлагатай байдаг. Үүний эсрэг шийтгэл үзүүлэх тусам зөрүүдлэх нь улам ихэсдэг. Ийм үед хүүхэд бүх зүйлийг маш сөргөөр хүлээж авч эхэлдэг. Хэрэв эцэг эх үүнийг анхаарахгүй, байнга буулт хийгээд байвал хүүхэд ингэж амжилтад хүрч болох юм

байна гэдэг буруу ойлголт суухад хүрч улмаар энэ зан нь удаан хадгалагдах болно.

- 4-5 настай хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлийг хянаж чаддаг болох ба юу зөв юу буруу болохыг мэдэж эхэлдэг ба энэ үеэс эхэлж зөрүүд зан үгүй болж эхэлдэг. 5-6 наснаас эхэлж хүүхдийн дургүйцлийн хэлбэр нь том хүнийхтэй төстэй болох ба ихэвчлэх бусад хүмүүстэй харьцах харьцаанаас шалтгаалсан хэлбэртэй болдог.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ зан үйлийг ажиглан, багш, сурган хүмүүжүүлэгч, мэргэжлийн хүмүүстэй хамтран хүүхдийнхээ сөрөг зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийнэ, хүүхдийн хүмүүжилд анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл: хүүхэд бага байх тусмаа төвөггүй мэт боловч ямар хүн болох үндсэн төрх төлөв, зан суртахууны үндэс энэ үед тавигддаг. Бага насны хүүхдийн сэтгэхүйн хөгжил нэн хурдацтайн дээр нэг хэмээр жигд тогтуун явагддаггүй, эмзэг, ээдрээтэй, огцом өөрчлөгдөж байдаг. Иймээс онцлог бүрийг олж харж, зөв хандахгүй, сэтгэлийг нь ойлгохгүй, буруу шаардлага тавих, хүүхдийг үл тоомсорлон хөндий байснаас хүүхэд буруу зан төлөв олж авдаг.

Хүүхдийн зөв төлөвшил нь эцэг эхээс шууд хамаардаг гэдгийг хүн бүр мэддэг хэдий ч хүүхдийнхээ санал бодлын сонсоод юуг болох, юуг болохгүй талаар харилцан ярилцах, ойлгож харилцах байдал дутмаг байна. Харин “бид их ажилтай, завгүй” гэх, гэрийн бүлийн эдийн засагтаа их анхаардаг байдал нөлөөлдөг. Хүүхдээ алс ирээдүйд ямар хүн болоосой гэж хүсэж байгаагаа тунгаан бодож бид өдөр тутам яг одоо тулгарсан асуудлаа шийдвэрлэхэд уур бухимдлаас зайлсхийж, сэтгэлийн хямралаа хэрхэн даван туулж хүүхэдтэйгээ найрсаг сайхан харилцаж хүүхдэдээ үлгэр жишээ үзүүлэх хэрэгтэй.

Орчин үед хот суурин газрын гэр бүлийн дийлэнх хэсэг нь амьдрах таатай орчин нөхцөлд амьдарч байгаа учраас хүүхэдтэйгээ танилцах хуучин арга барилыг ашиглахаа больсон.

Тухайлбал: түлээ мод бэлтгэх, ус зөөх, хоол ундаа зууханд хийх, гэрийн ямар нэг зүйлийг засах шаардлагатай байдаг байсан. Мөн тоглоомын идэвхтэй үйл ажиллагаа, байгаль орчин, хүмүүсийн мэдлэг, чадвар зэрэг нь урьд өмнөх үеийнх шиг биеийн хөдөлгөөн, оюун ухааны хүчин чармайлт шаарддаггүй. ТВ үзэх, компьютер, гар утас зэрэг нь тоглох, унших, бичих гэхээсээ илүү хялбар байдаг. Иймээс хүүхдүүдтэй эцэг эхчүүд хамт гэрийн ажил хийх, аялал зугаалгаар явах зэргээр чөлөө цагаа хамт их өнгөрөөж дотно, амьд харилцааг эрхэмлэх хэрэгтэй.

Ашигласан материал

- Бүрэнжаргал, Т., Ариунсанаа, Б. (2005). Эцэг эх нь гадаадад амьдарч буй хүүхдүүдийн зан үйлд гарч буй зарим өөрчлөлт. *Социологи-5*, 177.
- Гурова, Р.Г. (1981). Социологические проблемы воспитания. 45-46. Москва
- Дашням, Л. (онт бус). Монголчуудын хүн бүтээдэг эрдэм. Улаанбаатар
- Жуков, В.В. (2009). *Семья и семейное воспитание: кросс-культурный анализ на материале России и США*. 420. Москва
- Ичинхорлоо, Ш. (2012). Хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ. Улаанбаатар
- Намжил, Т. (2005). Монгол гэр бүлийн ёс уламжлал. 188. Улаанбаатар
- Рыбцова, Л. Л., Меренков, А. В и др. (2013). *Социология воспитания [учеб. пособие]*. 73-68 Екатеринбург..
- Лесгафт, П.Ф. (2010). *Семейное воспитание ребенка и его значение*. 218. Москва
- Хатанбаатар, А. (1978). *Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил*. 57. Улаанбаатар
- Эрдэнэбат, Ж. (2017). Монгол улсын ерөнхий сайдын илгээлт. Гэр бүл хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин, 4.

По изучение негативное поведение ребенка результаты исследования

С.Тулга

*Национальный университет Монголии, кафедрой социологий
и социальной работа, докторантура*

Аннотация

Семья для ребенка является одновременно и средой обитания, и воспитательной средой. Влияние семьи особенно в начальный период жизни ребенка наиболее превышает другое воспитательное воздействие. Роль семьи в формировании личности определяется зависимостью: какая семья, такой и выросший в ней человек. Родители воспитывают, а дети воспитываются существующей семейной жизнью. Семья может жить дружно, относиться дружелюбно к чужим людям, но может и ссориться, злобствовать, проявлять черствость, недоброжелательность не только к посторонним, но и к своим близким. Семья может жить духовными интересами, любить искусство и литературу или целиком уйти в конфликты, хозяйственную сутолоку. Жизнь семьи тем и сильна, что впечатления ее постоянны, обыденны, что она действует незаметно, укрепляет или отравляет дух человеческий, как воздух, которым мы дышим, укрепляет или отравляет наш физический организм. Успешность семейного воспитания определяется во многом тем, что родители являются не только советчиками, но и эталоном для своих детей. Родители как образец для подражания значимы для ребенка на всех этапах его развития. Методы воспитания детей в семье - это пути, с помощью которых осуществляется целенаправленное педагогическое влияние родителей на сознание и поведение детей. Методы семейного воспитания несут на себе яркий отпечаток личности родителей и неотделимы от них. Именно в семье ребенок получает первый жизненный опыт, делает первые наблюдения и учится как себя вести в различных ситуациях. Очень важно, чтобы то, чему мы учим ребенка, подкреплялось конкретными примерами, чтобы он видел, что у взрослых теория не расходится с практикой.

Ключевые слова

Семья, ребенка, родительские отношения, воспитание детей, негативное поведение